



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХАН ХЭНТИЙ
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын дарга ,тэргүүлэх аудитор
Ч. Эрдэнэбаатар
Утас:70562112 70562147

Аудитын менежер :
Д.Оюунтуяа
Утас: 70562147

Хаяг:
Хэнтий аймаг дахь Төрийн
Аудитын Газар
Хэнтий аймаг
Хэрлэн сум
Сариг баг
Монгол улс
Цахим хуудас:

www.khentii@audit.gov.mn

“Ай Жэй Эй Эйч Аудит “ ХХК
Захирал: Г.Энхмаа
Утас:99040059 450279
Цахим хаяг:
ljah_audit_2008@yahoo.com

АУДИТЫН ТАЙЛАН

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ХЭА-2018/18/-СТА-ХАК-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд, санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 12 дугаар сарын 23-аас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ний аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургууль нь төсвийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 07-нд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Ай Жэй Эй Эйч Аудит ХХК нь аудитыг 2017 оны 12 дугаар сарын 23-аас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 26-нд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн удирдлагад гардуулна.

2.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Төрийн албаны тухай”, “Бага дунд боловсролын тухай”, “Боловсролын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “ХХОАТ-ын тухай”, “Төрийн албаны тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Шилэн дансны тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт нэмж мөрдөх Монгол улсын их хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоол батлагдсан байна.

3.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн эрхэм зорилго нь: “Суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлж, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах авъяас чадвараа хөгжүүлэх, амьдрал хөдөлмөрт тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд тусална “ гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн 2017 оны төсвийг Боловсрол Соёл шинжлэх ухааны яамнаас аймгийн Төрийн сангаар дамжуулан олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар 7 дансанд 14 аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байгаа боловч энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС-тай нийцүүлж зарим зүйл заалтыг өөрчлөх шаардлагатай байна. ОУ-ын стандарттай нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий цогцолбор сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5.Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал”-ын дагуу “CTS” програмаар тус тус нягтлан бодох бүртгэлээ хөтлөн санхүүгийн тайланг гаргажээ. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

6.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс төсвийн төлөвлөгөөний дагуу 1,071,055.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааныхаа зардалд 1,070,680.3 мянган төгрөгийг зарцуулж 374.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээр төсвийн дээд шатны байгууллагаас 7,112.6 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 5,270.0 мянган төгрөг олж 12,382.6 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

7.Шилэн дансны мэдээлэл

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн www.shilendans.gov.mn вебсайт хуудсанд байршуулсан шилэн дансны мэдээллийг шалгахад жилийн эцсийн байдлаар Төсвийн гүйцэтгэлд 9 төрлийн мэдээлэл, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтад 5 төрлийн мэдээлэл, бусад мэдээлэлд 6 төрлийн мэдээллийг байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалттай байна.

8.Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн зардал хооронд гүйлгэж бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас хөрөнгө, урсгал зардлын материал худалдан авсан, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хэтрүүлэн зарцуулсан, эд хариуцагчийн тайланд тооцоо бодсон акт

үйлдээгүй, бараа материалын дансны ангилалыг буруу сонгож бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасныг баримталж тооцсон зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийн шаардлагыг хангахгүй байна.

9.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, авлага, өглөг, зардлын дансдаас цалин нийгмийн даатгалын шимтгэл, хоол, үдийн цай, хичээл сургалтын зардал, шуудан холбоо, томилолт, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын дансдад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 95%, мөнгөн хөрөнгийн 90 %, нийт зардлын 70% , нийт хөрөнгийн 70%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа 12 судалгааг гаргуулан авсан. Тайлант хугацаанд сургуулийн дотуур байрны засварт БСШУС-яамнаас ирсэн тусгай зориулалтын шилжүүлгийн 4,300.0 мянган төгрөгийн дүнтэй хөрөнгийн засварын ажлыг дотуур байрны 3 тасагт хийсэн байна.

10.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Төлөвлөлтийн үед материаллаг байдлыг 2-р улирлын орлого үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1% буюу 11,711.9 мянган төгрөгөөр тооцов./ТАБ-СТА-А-4/ Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцож 4-р улирлын орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1% буюу 12,004.7 мянган төгрөгөөр тогтоов. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна Үүнд:

1. Тус байгууллага нь бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 4,623.5 мянган төгрөгийн эд хогшил, урсгал засварын материал худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 73.5-д “ Зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх” журмыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид төсвийн зардлыг хэмнэх, зардлын зүйлийг хэтрүүлэхгүй байх талаар зөвлөмж өгөх.

3. Тайлант жилд тус байгууллагын няравын тайлангаарх дотуур байрны хүүхдийн тоо, дотуур байрны багшийн ирцийн бүртгэлээс зөрүүтэй, 1 хүүхдийн хоолны нормыг хэтрүүлэн 324.4 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна. Эд хариуцагч хоол хүнсний зарцуулалтын тайланг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж тайланг гаргаагүй, Нягтлан бодогч эд хариуцагчийн тайланг хүлээн авч тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байсан нь Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27 ны өдрийн 106 тоот тогтоолоор “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 (хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тогтоосугай” гэж заасныг, 2.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Цаашид дотуур байрны хүүхдийн хоолны зардалд анхаарах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, эд хариуцагчийн тайланг тооцоо бодсон актаар баталгаажуулж хэвшихийг зөвлөж байна.

4. Санхүүгийн байдлын тайлангийн Бараа материалын дансдын ангилалд үдийн цайны материалыг “сэлбэг хэрэгсэл”-н дансанд бүртгэж ирсэн нь Сангийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот тушаалын 5 дугаар хавсралтаар Балансын дансны жагсаалт баталсныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид балансын дансны ангилалыг зөв, ойлгомжтой байдлаар бүртгэж, тайлагнах талаар зөвлөмж өгөх

5. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо байгууллага нь Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасныг баримталсан нь уг тушаал 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 297 тоот тогтоолоор хүчингүй болсон тул тухайн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ өөрчлөлт оруулж УСНББОУС-н дагуу элэгдлээ тооцоогүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програмдаа өөрчлөлт оруулахыг зөвлөв.

11.Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг бус 4,947.9 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй тул дахин давтахгүй байх зөвлөмж өгөв.

12.Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

13.Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

14.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн дүнгээр нийт 4,947.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрэв.

15.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК аудит хийсэн ба зөрчилгүй дүгнэлт өгсөн байна. Аудитаар 163.5 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 1 акт, 5 зөвлөмж өгсөний хариуг аймгийн Төрийн Аудитын газар хүргүүлсэн байна. Өмнөх зөвлөмжийн 80%-г биелүүлж ажилласан байна.

16.Зөрчилгүй санал дүгнэлт

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 11 хуудас, хавсралтууд 18 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Handwritten signature in black ink

Ч.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Д.ОЮУНТУЯА ОГНОО:

Handwritten signature in blue ink

Н.УРАНЧИМЭГ ОГНОО: 2018.02.25



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.28 № 06/39
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР



ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХАН ХЭНТИЙ
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Зардал хооронд гүйлгэсэн талаар.....	3
Асуудал 2	
Дотуур байрны хоолны зардлын талаар.....	4
Асуудал	
Бараа материалын дансны ангилалын талаар.....	5
Асуудал 4	
Үндсэн хөрөнгийн элэгдийн талаар.....	6

2018 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын Хан Хэнтий Цогцолбор сургуулийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, албан тоотыг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Хэнтий аймгийн Аудитын Газар болон Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлнэ.

АГ-ын ажиглалт

Тус байгууллага нь бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 4,623.5 мянган төгрөгийг эд хогшил урсгал засварын материал худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасан, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан зардлын эдийн засгийн ангилалыг ашиглах заавар, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 73.5-д зардал хооронд шилжүүлэх зөвшөөрлийн талаар заасныг мөрдөж ажиллаагүй байна.

АГ-ын зөвлөмж

Цаашид холбогдох тушаал, заавар, журмын дагуу төсөвт зохицуулалт хийх, зардал хооронд шилжүүлэх зөвшөөрөл авах, зардал хэтрүүлэхийг таслан зогсоох.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй. УСНББОУС-г зөрчих эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч албан тоотоор хариу ирүүлэв.

АГ-ын ажиглалт

Тайлант жилд тус байгууллагын няравын тайлангаарх дотуур байрны хүүхдийн тоо, байрны багшийн ирцийн бүртгэлээс зөрүүтэй, хүүхдийн хоолны 1 өдрийн нормыг хэтрүүлэн зарцуулж ирсэн байна. Тулган шалгахад 1 хүүхдэд олгосон хоолны зардал жилийн дүнгээр нормоос 324.4 мянган төгрөгөөр илүү байгаа нь: 1. Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27 ны өдрийн 106 тоот тогтоолоор “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 (хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тогтоосугай” гэж заасныг, 2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

АГ-ын зөвлөмж

1. Дотуур байрны хүүхдийн хоолны норм, нормативыг баримтлах, Нягтлан бодогч, эд хариуцагчийн хоолны тайланг шалгаж тооцоо бодсон актаар баталгаажуулж хэвших.
2. Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-д заасныг мөрдөж ажиллахыг тус тус зөвлөж байна.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч албан тоотоор хариу ирүүлэв.

Асуудал 3: Бараа материалын дансны ангилалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

АГ-ын ажиглалт

Санхүүгийн байдлын тайлангийн Бараа материалын бүлгийн үдийн цайны материалыг сэлбэг хэрэгсэл гэсэн дансанд бүртгэж ирсэн нь Сангийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот тушаалын 5 дугаар хавсралтаар Балансын дансны жагсаалт баталсаныг мөрдөж ажиллаагүй байна.

АГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайлангийн Балансын дансны заавар, дансдын ангилалыг дахин судлаж бараа материалыг зөв ангилж бүртгэхийг зөвлөж байна.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч албан тоотоор хариу ирүүлэв.

АГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан байна. Мөн УСНББОУС-17-д заасантай нийцэхгүй байна.

АГ-ын зөвлөмж

НБББББ-г шинээр боловсруулж хөрөнгийн элэгдлийн хугацааг тогтоож мөрдөх. УСНББОУС-17-н 90-д заасныг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

УСНББОУС- 17-д заасныг зөрчих эрсдэлтэй.


Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрч албан тоотоор хариу ирүүлэв.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР




Ч.ЭРДЭНЭБААТАР
Д.ОЮУНТУЯА

Огноо:
Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Н.УРАНЧИМЭГ Огноо: 2018.02.24